



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/506

Улаанбаатар хот

МУИС-ийн Цахим сургалтын журмыг
шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 11.3, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.9 дэх заалт, МУИС-ийн ректорын зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “МУИС-ийн цахим сургалтын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн захирал (ректор)-ын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/89 тоот тушаалаар батлагдсан “МУИС-ийн цахим сургалтын түр журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.


3. Энэхүү журмыг холбогдох нэгжүүдэд сурталчлан, хэрэгжүүлж ажиллахыг Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих төвийн эрхлэгч (С.Отгонцэцэг), Цахим шилжилтийн газрын дарга (А.Баатарбилэг), Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газрын дарга (С.Булгантамир), Оюутны хөгжлийн газрын дарга (Б.Цэцэнцолмон), бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирлууд (Б.Болд-Эрдэнэ, Ц.Амартайван, Н.Батнасан, Б.Амарсанаа, Ч.Сономдавга, Б.Ганбат, Ц.Пүрэвсүрэн, Д.Алтанхуяг, Б.Мядагмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Журмын хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар)-т үүрэг болгосугай.

РЕКТОР  Б.ОЧИРХУЯГ

1425064464

Монгол улсын их сургуулийн ректорын
2025. оны 10 сарын 31-ний өдрийн
А/506 тоот тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЦАХИМ СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, МУИС-ийн оюуны өмчийн талаар баримтлах бодлого болон МУИС-ийн стратеги төлөвлөгөө, дотоод дүрэм, журмын хүрээнд МУИС-д цахим хичээл төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, үүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Журмын зорилго нь боловсролын тэгш хүртээмжийг хангах, насан туршийн боловсролыг дэмжих, цахим сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.
- 1.3. Цахим хичээл боловсруулах, цахим сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааны хамрах хүрээ нь МУИС-ийн зэргийн сургалтын хөтөлбөрт (бакалавр, магистр, доктор) тусгагдсан асинхрон цахим хичээл, зэргийн бус сургалтын цахим хичээл болон нийтэд зориулсан нээлттэй цахим хичээл байна.

Хоёр. Журмын нэр томьёо

- 2.1. Хичээлийн багц материал гэж сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад багшийн урьдчилан бэлтгэх шаардлагатай бүх төрлийн хэрэглэгдэхүүнийг;
- 2.2. Цахим хичээл гэж хичээлийн багц материалыг суралцагчдад орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэдээллийн технологийн тусламжтайгаар бие даан судлах боломжтой байдлаар зохиомжлон боловсруулсан хичээлийг;
- 2.3. Бүрэн цахим хичээл гэж хичээлийн багц материалын бүх төрөл, хэлбэрийг цахим хэлбэрт шилжүүлж боловсруулсан хичээлийг;
- 2.4. Холимог цахим хичээл гэж хичээлийн багц материалын зарим хэсгийг танхимаар явуулахаар төлөвлөсөн, цахим болон танхимын сургалт хосолсон хэлбэрийн хичээлийг;
- 2.5. Сургалтын харилцаа гэж сургалтын явцад багш, суралцагчдын хооронд үүсэх харилцааны (агуулга дамжуулах, зөвлөгөө дэмжлэг, үнэлгээ хийх) хэлбэрийг;
- 2.6. Цахим сургалт гэж цахим хичээлийг суралцагчдад цахимаар хүргэж, суралцах үйл ажиллагааг зохион байгуулах үйл явцыг;
- 2.7. Бүрэн цахим сургалт гэж сургалттай холбоотой бүхий л харилцаа, үйл ажиллагаа цахимаар явагдах сургалтын хэлбэрийг;
- 2.8. Асинхрон цахим сургалт гэж цахим хичээлийг орон зай, цаг хугацаанаас хамааралгүйгээр суралцагчид хичээлийн агуулга, материалтай өөрийн цагийн хуваарийн дагуу хандаж, суралцах боломжтой, багш болон

суралцагчид нэгэн зэрэг сургалтын үйл ажиллагаанд оролцох шаардлагагүй цахим сургалтын хэлбэрийг;

- 2.9. Синхрон цахим сургалт гэж багш болон суралцагчид ижил цаг хугацаанд, цахим орчныг ашиглан бодит хугацаанд (real-time) холбогдож, хичээлийн үйл явцад хамт оролцон харилцан ярилцаж, шууд хариу үйлдэл үзүүлэх боломжтой цахим сургалтын хэлбэрийг;
- 2.10. Зэргийн бус сургалт гэж дээд боловсролын сургалтын байгууллагын бакалавр, магистр, докторын үндсэн зэргийн хөтөлбөрөөс тусдаа шинжлэх ухааны аль нэг салбар, мэргэжлийн чиглэлээр мэдлэг, ур чадвар, хандлага олгох сургалтыг;
- 2.11. Нийтэд нээлттэй цахим хичээл гэж олон нийтэд зориулсан, өөрөө явагдах цахим хэлбэртэй, тодорхой хугацаанд эсвэл байнгын нээлттэй байх боломжтой, төлбөртэй эсвэл үнэгүй цахим хичээлийг;
- 2.12. Бүрэн цахим зэргийн хөтөлбөр гэж суралцах бүх үе шат (элсэлтээс төгсөлт хүртэл), сургалтын харилцаа цахим орчинд явагдах, бүх хичээлийг бүрэн цахим хэлбэрээр санал болгох боловсролын зэрэг олгох хөтөлбөрийг;
- 2.13. Цахим сургалтын платформ гэж цахим хичээлийг боловсруулж, хүргэх, суралцагчдын оролцоо, үнэлгээг удирдах зориулалттай программ хангамжийн цогцыг;
- 2.14. Цахим сургалтын зохиомж гэж цахим хичээлийн хэлбэр, онцлогт тулгуурлан сургалтын явцад үүсэх харилцааг хэрхэн оновчтой зохион байгуулах талаар нарийвчилсан төлөвлөлт, зааварчилгааг;
- 2.15. Агуулгын шаардлага гэж хичээлийн хөтөлбөрт тусгагдсан агуулгыг бүрэн хамарсан эсэхийг тодорхойлох шалгуурыг;
- 2.16. Технологийн шаардлага гэж цахим хичээлийн бүтэц, хэлбэр, түүний дүрс дуу, чанарт тавигдах техникийн шалгуур;

Гурав. Цахим сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт

- 3.1. Бүрэлдэхүүн/салбар сургууль нь:
 - 3.1.1. Цахим хичээл, цахим хөтөлбөр боловсруулах тухай тэнхимийн шийдвэрийг хэлэлцэн шийдвэрлэж, боловсруулагч талтай хамтын гэрээ байгуулах;
 - 3.1.2. Цахим хичээл боловсруулахаар гэрээ байгуулсан багшийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авах, сунгах, цуцлах тухай шийдвэр гаргах;
 - 3.1.3. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээл боловсруулахтай холбоотой зардлыг санхүүжүүлэх;
 - 3.1.4. Цахим сургалт явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;
 - 3.1.5. Цахим сургалтын хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх;
 - 3.1.6. Гадаад, дотоодын их дээд сургууль, байгууллагуудын цахим сургалт явуулж буй туршлага судлах, харилцаа тогтоож, хамтарсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх;

- 3.1.7. Нийтэд нээлттэй цахим хичээл боловсруулах болон олон нийтэд түгээх, борлуулахтай холбоотой гэрээ байгуулах, төлбөрийн нөхцөл, орлого хуваарилах талаар бодлого боловсруулах;
- 3.2. Тэнхим нь:
- 3.2.1. Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлийг цахим хэлбэрт шилжүүлэх санал гаргах;
- 3.2.2. Тэнхимийн харьяаллын хичээлүүдийг цахим хэлбэрт шилжүүлэх тухай төлөвлөгөө гаргаж ажиллах;
- 3.2.3. Цахим хичээл боловсруулах тухай шийдвэр гаргаж, бүрэлдэхүүн сургуулийн захиргаанд хүргүүлэх;
- 3.2.4. Цахим хичээлийн агуулгыг хянаж, дүгнэлт гаргах;
- 3.2.5. Цахим сургалтыг зохион байгуулах тухай санал гаргаж сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжид хүргүүлэх;
- 3.2.6. Цахим хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэж, хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлэх;
- 3.2.7. Цахим сургалтын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх, дүгнэх;
- 3.2.8. Нийтэд нээлттэй цахим хичээлийг боловсруулж, санал болгох санаачилга гаргах, хичээлийн контент, чанар, хүртээмжид хяналт тавих;
- 3.3. Цахим хичээл боловсруулах багш нь:
- 3.3.1. МУИС-ийн цахим бичлэгийн студийг ашиглах;
- 3.3.2. Хөтөлбөрт тусгагдсан хичээлийг цахим болгон боловсруулах тухай гэрээг бүрэлдэхүүн сургууль болон бусад оролцогч талуудтай байгуулж, мөрдөн ажиллах;
- 3.3.3. Цахим хичээлийг агуулга болон технологийн шаардлагын дагуу боловсруулах;
- 3.3.4. Цахим хичээл боловсруулах тухай чиглүүлэх сургалтад хамрагдах;
- 3.3.5. Нийтэд нээлттэй цахим хичээл боловсруулж, орлогоос хувь хүртэх тухай гэрээ байгуулах;
- 3.4. Цахим сургалт хариуцсан нэгж нь:
- 3.4.1. Цахим хичээл боловсруулах, цахим сургалт зохион байгуулах аргачлалын талаар сургалт зохион байгуулах, зааварчилгаа, гарын авлага, зөвлөмж бэлтгэх;
- 3.4.2. Цахим хичээл боловсруулж буй багшид технологийн зөвлөгөө өгөх;
- 3.4.3. Цахим хичээл нь технологийн шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргаж бүрэлдэхүүн сургуульд хүргүүлэх;
- 3.4.4. Цахим хичээлтэй холбогдох тоон мэдээ, баримтыг бүртгэх;
- 3.4.5. Цахим хичээлийн эх хувилбарыг архивлан хадгалах;
- 3.5. Мэдээллийн технологи хариуцсан нэгж нь:
- 3.5.1. Цахим сургалтын платформыг бэлтгэх, шинэчлэх, тогтвортой, найдвартай ажиллагааг хангах;

- 3.6. Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж нь:
- 3.6.1. МУИС-ийн сургалтын хөтөлбөр, хичээлийн онцлогоос хамааруулан тодорхой хичээлийг цахим хэлбэрт шилжүүлэх санал гаргах;
- 3.6.2. Цахим сургалтыг ерөнхий удирдлагаар хангаж, зохион байгуулах;
- 3.6.3. Цахим сургалтын гүйцэтгэлийн үр дүнд шинжилгээ хийж холбогдох санал, зөвлөмжийг харьяа тэнхим, цахим сургалт хариуцсан нэгжид хүргүүлэх;
- 3.6.4. Цахим сургалтын хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.6.5. Цахим хичээлийн чанар, хүртээмжийн судалгааг суралцагсдаас авах;
- 3.7. Технологи дамжуулах төв нь:
- 3.7.1. Цахим хичээл боловсруулах гэрээний шаардлагыг бүрэн хангаж, амжилттай дүгнэгдсэн Цахим хичээлийг МУИС-ийн оюуны өмчөөр бүртгүүлэх;
- 3.8. Санхүү бүртгэлийн газар нь:
- 3.8.1. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээл боловсруулах гэрээний шаардлагыг бүрэн хангаж, амжилттай дүгнэгдсэн цахим хичээлийг санхүүгийн тайланд МУИС-ийн биет бус хөрөнгөөр бүртгэж авах;
- 3.8.2. Нийтэд нээлттэй цахим хичээлээс орлого олж байгаа тохиолдолд төлбөртэй холбоотой үйл ажиллагааг хянах, зохион байгуулах;
- 3.9. Цахим хичээл заах багш нь:
- 3.9.1. Цахим сургалтын платформыг ашиглан цахим сургалт зохион байгуулах хичээлийг үзэж судалсан байх;
- 3.9.2. Цахим сургалтыг холбогдох дүрэм журмын хүрээнд зохион байгуулах;
- 3.9.3. Суралцагчтай тогтмол харилцаж, сургалтын үйл явцыг хянах, үнэлэх;
- 3.9.4. Суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх талаар санаачилгатай ажиллах;
- 3.10. Суралцагч нь:
- 3.10.1. Суралцагч нь танхимын сургалттай нэгэн адил цахим хичээлийг сонгон судлах;
- 3.10.2. Суралцагчид зориулсан цахим хичээл судлах зааварчилга, хичээлийн мэдээлэлтэй танилцах;
- 3.10.3. Суралцагч нь МУИС-ийн дүрэмд заасан бусад эрх, үүргийг хүлээнэ.

Дөрөв. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээл

- 4.1. Цахим хичээл боловсруулах үйл ажиллагаа нь хичээлийн агуулгыг цахим орчинд үр дүнтэй, суралцагч төвтэй байдлаар хичээлийн багц материалыг боловсруулж, бүтэцчилэн зохиомжлох үе шаттай үйл явц юм.

- 4.1.1. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийг МУИС-ийн үндсэн орон тооны багш дангаар, эсвэл үндсэн орон тооны багшаар ахлуулсан баг хамтран боловсруулна.
- 4.1.2. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийг шинээр боловсруулах, өөрчлөх тухай саналыг багш, тэнхим эсвэл сургалт хөтөлбөр хариуцсан нэгж гаргаж болох бөгөөд уг саналыг тэнхим, нэгжийн хурлаар хэлэлцэн дэмжсэн тохиолдолд шийдвэрийг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлд хүргүүлнэ.
- 4.1.3. Хичээлийг цахим хэлбэрт шилжүүлэх саналыг тэнхим, нэгжийн хурлын дэмжсэн шийдвэрийг үндэслэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөл эцэслэн гаргана.
- 4.1.4. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээл боловсруулах саналыг хичээлийн жилийн үндсэн улирлын эхний 3 долоо хоногт багтаан гаргаж бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөл саналыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 4.1.5. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийг МУИС-ийн бакалавр, магистр, докторын зэргийн хөтөлбөрт тусгагдсан хичээлийн агуулгын хүрээнд боловсруулна.
- 4.1.6. Бакалаврын сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлийг зөвхөн холимог (лекцийн агуулгыг цахимаар) цахим хичээлээр, магистр, докторын сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлийг холимог эсвэл бүрэн цахим хэлбэрээр боловсруулна.
- 4.1.7. Бакалаврын түвшний семинар, лабораторийн хичээлийг цахим хэлбэрт шилжүүлэхгүй.
- 4.1.8. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийг Цахим хичээлд тавигдах технологийн шаардлага (Хавсралт 1)-ын дагуу боловсруулна.
- 4.1.9. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийг боловсруулах багш нь бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал болон бусад оролцогч талуултай журмын дагуу батлагдсан жишиг гэрээ (Хавсралт 2)-ний дагуу гэрээ байгуулан мөрдөж ажиллана.
- 4.1.10. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийн боловсруулах явцад цахим сургалт хариуцсан нэгж технологийн зөвлөмж өгч, тэнхимийн зүгээс агуулгын хяналт тавьж ажиллана.
- 4.1.11. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийг цахим сургалтын платформд бүрэн байршуулсны дараа гэрээний гүйцэтгэлийг дүгнэх хүсэлтийг Гэрээ гүйцэтгэлийн акт (Хавсралт 3)-ын дагуу бүрэлдэхүүн/салбар сургуульд гаргана.
- 4.1.12. Цахим сургалт хариуцсан нэгж цахим хичээл технологийн шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргана. Харьяа тэнхимээс цахим хичээл хөтөлбөрийн агуулгын шаардлагыг хангаж буй дүгнэлт гаргана.

- 4.1.13. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийн технологийн болон агуулгын шаардлагын дүгнэлтийг үндэслэн (Гэрээний гүйцэтгэлийн акт) бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөл гэрээг дүгнэнэ.
- 4.1.14. Агуулгын болон технологийн шаардлагын аль нэгийг хангаагүй, эсвэл гэрээнд заасан бусад нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд цахим хичээлийн талаар авах арга хэмжээний талаар бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөл шийдвэр гаргана.
- 4.1.15. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлтэй холбоотой оюуны өмчийн эрхийг МУИС эзэмшинэ.
- 4.1.16. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийг боловсруулагч багш болон санхүүжүүлэгч нь хичээлийг нийтийн хүртээл болгох, ашиглах тухай бүрд нэрээ дурдуулах амины эрх эдэлнэ.
- 4.1.17. Хичээлийн хөтөлбөрийн агуулгад өөрчлөлт орсон тохиолдолд цахим хичээлд шаардлагатай өөрчлөлт оруулах бөгөөд энэ талаар гэрээлэгч талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 4.1.18. Зэргийн хөтөлбөрийг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх тохиолдолд тэнхим, бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөрийн хороо, МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 4.2. Цахим хичээл боловсруулсан багшийн урамшуулал
- 4.2.1. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээл боловсруулсан багшид өгөх урамшууллыг МУИС-ийн захиалгаар цахим хичээл боловсруулах гэрээний (Хавсралт 2) дагуу олгоно. Урамшууллын санхүүжилтийг захиалагч тал хариуцах ба захиалагч нь МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургууль, түнш байгууллага, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэгч тал байж болно.
- 4.2.2. Багшид олгох урамшууллыг тооцохдоо хичээлийн багц цаг ба хичээлийн багц материалын төрөл, хэлбэрийг цахим хэлбэрт шилжүүлсэнд үндэслэн доорх жишиг багц цагийн тооцооллоор тооцно.

№	Төрөл	1 долоо хоногт /цагаар/				Давтамж	Улирал /цагаар/	БЦ
		Бэлтгэх	Бичүүлэх	Засварлах	Нийт			
1	Лекц (бакалавр, 2 БЦ)	4	3	2	9	16	144	3
2	Лекц (ахисан, 2 БЦ)	7	3	2	12	12	144	3
3	Семинар (ахисан, 1 БЦ)	4	3	1	8	12	96	2
4	Шалгалтын сан (ахисан)	12	0	0	12	2	24	0.5

- 4.2.3. Нэг багц цагийн үнэлгээг МУИС-д мөрдөгдөж буй сургалтын ажлын (А цаг) илүү цагийн үнэлгээгээр тооцож, урамшууллын дүнг тогтооно.
- 4.3. Цахим сургалтыг зохион байгуулах

- 4.3.1. Зэргийн хөтөлбөрийн цахим хичээлийг сургалтын хөтөлбөрт тусгасан хичээлийн улиралд багш болон тэнхимээс гаргасан саналд үндэслэн зохион байгуулна.
- 4.3.2. Зэргийн хөтөлбөрийн хичээлийг нэг улиралд танхим болон асинхрон цахим хэлбэрээр зэрэг зохион байгуулах боломжтой.
- 4.3.3. Цахим сургалтыг МУИС-ийн цахим сургалтын албан ёсны платформ ашиглан хэрэгжүүлнэ.
- 4.3.4. Бакалаврын хөтөлбөрийн цахим хичээлийг зөвхөн холимог, ахисан түвшний цахим хичээлийг холимог эсвэл бүрэн цахим сургалтын хэлбэрээр хүргэнэ.
- 4.3.5. Цахим сургалтын хүрээнд суралцагчийн бүртгэл, хичээл сонголт, үнэлгээ, төгсөлт зэрэг үйл ажиллагаа нь МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журмын хүрээнд зохицуулагдана.
- 4.3.6. Бүрэн цахим зэргийн хөтөлбөрийг МУИС-ийн Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журмын дагуу боловсруулж, МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 4.4. Цахим хичээл удирдан явуулсан багшид багц цаг тооцох
- 4.4.1. Цахим хичээлийг сонгон баталгаажуулсан суралцагчдын тоонд үндэслэн МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журмын хүрээнд нээж багшид багц цагийн гүйцэтгэл тооцно.
- 4.4.2. Цахим сургалтын үйл ажиллагаа нь суралцагчдын оролцоог хянах, шинжлэх, зөвлөгөө хэлэлцүүлэг, мэдлэг, чадварыг үнэлэх гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд дараах сургалтын төрөлд хамаарах цагийг 1 багц цаг гэж ойлгоно.

№	Сургалтын хэлбэр	Суралцагчдын оролцоог хянах, шинжлэх	Зөвлөгөө хэлэлцүүлэг	Мэдлэг, чадварыг үнэлэх	Нийт
1	Лекц	8	24	16	48
2	Семинар	8	32	8	48

- 4.4.2.1 *Суралцагчдын оролцоог хянах, шинжлэх:* Цахим сургалтын систем дээр суралцагчийн хичээлийн идэвх, ахиц, даалгаврын биелэлт, тестийн гүйцэтгэл, явцын тайлан, хэлэлцүүлэгт оролцоо зэрэг мэдээлэлд тулгуурлан суралцах явцыг дүн шинжилгээ хийх, эдгээр мэдээлэлд үндэслэн шаардлагатай чиглэл, зөвлөмжийг өгнө.
- 4.4.2.2 *Зөвлөгөө хэлэлцүүлэг:* цахим сургалтын системийн форум, асуулт-хариултын хэсэг болон бусад системээр дамжин суралцагчдаас ирэх санал хүсэлт, асуултад тодруулга, зөвлөгөө өгч, бүлгийн хэлэлцүүлэг өрнүүлж, мэдлэгийн солилцоог дэмжих
- 4.4.2.3 *Мэдлэг, чадварыг үнэлэх:* суралцахуйн үр дүнг даалгавар, тест, шалгалт, бие даалт болон бусад төрлийн үнэлгээний хэлбэрээр шалгах, үнэлэх. Системийн үнэлгээний шалгуур (rubric), хугацаа, автомат оноолт болон үнэлгээ хийх боломжийг бүрдүүлнэ.

- 4.4.3. Багшид тооцох сургалтын багц цагийг суралцагчдын тооноос хамааруулан МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журмын 6.2 заалтын дагуу тооцно.
- 4.4.4. Тухайн багшийн цахим сургалтын үйл ажиллагаагаар цуглуулах нийт сургалтын багц цаг нь тухайн багшийн албан тушаалын зэрэглэлийн гүйцэтгэх сургалтын багц цагийн 40%-иас хэтрэхгүй байна. Уг заалт нь бүрэн цахим зэргийн хөтөлбөрийн хичээлийг хамаарахгүй.
- 4.5. Цахим хичээлийн чанарын үнэлгээ
- 4.5.1. Цахим сургалтын чанарын үнэлгээ нь багшийн гүйцэтгэл, суралцагчийн суралцахуйн үр дүн, идэвх оролцоо, сэтгэл ханамж зэрэг үзүүлэлтэд үндэслэн хийгдэнэ.
- 4.5.2. Цахим сургалтын үйл ажиллагаанд сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж явцын хяналт тавьж ажиллана.
- 4.5.3. Чанарын үнэлгээг сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж гүйцэтгэх бөгөөд дараах аргачлалыг ашиглана. Үүнд:
- Цахим сургалтын платформын өгөгдөл (оролцоо, гүйцэтгэл);
 - Суралцагчийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгаа;
- 4.5.4. Цахим сургалтын чанарын нэгдсэн шинжилгээг дараагийн улирлын эхэнд сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж хийж холбогдох санал, зөвлөмжийг харьяа тэнхимд хүргүүлнэ.
- 4.5.5. Тэнхим нь цахим сургалтын үйл ажиллагаатай холбоотой санал зөвлөмжид үндэслэн хичээлийн үр дүнг сайжруулах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.5.6. Цахим сургалт хариуцсан нэгж нь цахим сургалтын чанарын үнэлгээний мэдээлэлд үндэслэн платформ, дэмжих үйлчилгээ, журмыг шинэчлэн сайжруулах талаар санал боловсруулж МУИС-ийн захиргаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

Тав. Нийтэд нээлттэй цахим хичээл

- 5.1. Нийтэд нээлттэй цахим хичээлийг боловсруулах
- 5.1.1. Нийтэд нээлттэй цахим хичээлийг сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж, бүрэлдэхүүн/салбар сургууль, цахим сургалт хариуцсан нэгж, багшийн саналаар боловсруулж олон нийтэд санал болгоно.
- 5.1.2. Хичээлийн зорилтот бүлэг, агуулга, хэлбэр (бүрэн цахим, богино сургалт, мастеркласс гэх мэт)-ийг тодорхойлж, хэрэгцээт сургалтын загварыг боловсруулна.
- 5.1.3. Нийтэд нээлттэй цахим хичээл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Хэрэглэгчдэд энгийн, хүртээмжтэй байх;
 - Мэргэжлийн түвшинд боловсруулсан сургалтын материал;
 - Үнэлгээний бүтэцтэй байх (сорил, даалгавар, гэрчилгээ гэх мэт);

- 5.1.4. Хичээл боловсруулахад тэнхим, багш, сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж, цахим сургалт хариуцсан нэгжтэй хамтран ажиллах ба хичээл боловсруулах баг томилж болно.
- 5.1.5. Нийтэд нээлттэй цахим хичээлийг хэрхэн зохион байгуулахыг хичээлийн зорилтот бүлэг, агуулга, хэлбэрээс хамааруулан цахим сургалт хариуцсан нэгж, холбогдох тэнхим, бүрэлдэхүүн/салбар сургууль төлөвлөнө.
- 5.1.6. Нийтэд нээлттэй хэлбэрийн цахим хичээлд зориулсан англи хэл дээрх ашиглалтын лиценз (Creative Commons гэх мэт), хамгаалалтын тэмдэглэл хавсаргасан байна.
- 5.2. Нийтэд зориулсан цахим сургалтыг зохион байгуулах
- 5.2.1. Нийтэд нээлттэй цахим хичээлийг асинхрон хэлбэрээр үндэсний хэмжээнд зохион байгуулах бол МУИС-ийн нийтэд нээлттэй цахим сургалтын платформ дээр зохион байгуулна. Олон улсын түвшинд зохион байгуулах бол тохирох платформыг хичээл боловсруулах баг (цахим сургалтын нэгж, холбогдох тэнхим, бүрэлдэхүүн/салбар сургууль), санхүүжүүлэгчийн саналд үндэслэн Сургалт эрхэлсэн проректор шийднэ.
- 5.2.2. Сургалтад оролцогчдын бүртгэл, оролцооны тоон үзүүлэлт, үнэлгээ, гэрчилгээ олголтыг нийтэд нээлттэй цахим сургалтын платформоор хөтөлнө.
- 5.2.3. Цахим сургалтын зохион байгуулалт, чанарын хяналтыг цахим сургалт хариуцсан нэгж, сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж, харьяа тэнхим, хичээл боловсруулах баг хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2.4. Сургалтын төгсгөлд оролцогчдод гэрчилгээ олгох эсэхийг сургалтын бүтэц, үнэлгээний шалгуурт үндэслэн шийднэ. Гэрчилгээ нь МУИС-ийн албан ёсны баталгаажуулалттай байна.
- 5.2.5. Зэргийн бус сургалтад нийтэд нээлттэй цахим хичээлийг ашиглаж болно.
- 5.3. Төлбөр, санхүүжилт
- 5.3.1. Нийтэд нээлттэй цахим хичээлийг боловсруулах санхүүжилтийг дараах хэлбэрээр бүрдүүлж болно. Үүнд:
- Гадаад болон дотоод төслийн санхүүжилт;
 - Төлбөртэй, зэргийн бус цахим сургалтын орлого;
 - Хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын захиалгат сургалт;
- 5.3.2. Нийтэд нээлттэй цахим хичээлийг боловсруулах үүрэг хүлээсэн багш, хичээл боловсруулах багт олгох урамшууллыг захиалагч тал хариуцна. Урамшууллын дүн, олгох нөхцөл, хугацааг оролцогч талуудын байгуулсан гэрээгээр тохиролцоно.
- 5.3.3. Нийтэд нээлттэй цахим хичээлийг төлбөртэй санал болгох бол төлбөрийн хэмжээг МУИС-ийн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр тогтооно.

- 5.3.4. Нийтэд нээлттэй цахим хичээлийг төлбөртэй, хэлбэрээр санал болгосон тохиолдолд орлогын хуваарилалтыг МУИС-ийн Санхүүгийн бодлого, холбогдох журмын дагуу боловсруулсан гэрээ, төлөвлөгөөнд үндэслэн гүйцэтгэнэ. Хичээл боловсруулсан багшид гэрээнд заасан дагуу орлогын хувийг урамшуулал хэлбэрээр олгож болно.
- 5.3.5. Цахим сургалт хариуцсан нэгж нь нийтэд нээлттэй цахим хичээлийн хөгжүүлэлт, борлуулалт, чанарын менежмент, үр дүнгийн шинжилгээг хийж саналыг МУИС-ийн захиргаанд танилцуулна.

Зургаа. Бусад

- 6.1. Цахим хичээлийн багц цагийн төлбөр нь танхимын сургалтын харгалзах багц цагийн төлбөртэй ижил байна.
- 6.2. Оюуны өмчийн зөрчилтэй холбоотой маргааны оюуны өмчийн эрх, түүнд холбогдох хууль журмаар шийдвэрлэнэ.
- 6.3. Цахим хичээлийн агуулгатай холбоотой гуравдагч талын маргааныг сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжид мэдүүлэх ба нэгжийн зүгээс холбогдох бүрэлдэхүүн/салбар сургууль, тэнхимийн тайлбар, саналыг авч эргүүлэн мэдэгдэнэ.
- 6.4. Цахим сургалтыг зохион байгуулахтай холбоотойгоор энэхүү журамд тусгагдаагүй асуудал гарвал МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журмыг баримтална.
- 6.5. Энэхүү журам болон Сургалтын үйл ажиллагааны журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал захиргааны зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ.

Цахим хичээлд тавигдах технологийн шаардлага

1. Ерөнхий шаардлага
 - 1.1. Цахим хичээлийн агуулга нь хичээлийн хөтөлбөр, суралцахуйн үр дүнг бүрэн хамарсан байна.
 - 1.2. Хичээлийн агуулга нь оюуны өмчийн болон зохиогчийн эрхийн зөрчилгүй байх ба ашигласан материалд лавлагаа, зохиогчийн эрхийн зөвшөөрөл хавсаргасан байна.
 - 1.3. Цахим хичээлийн бүх контент (дүрс бичлэг, танилцуулга, тест, материал) дээр МУИС-ийн лого, “© МУИС, он, Бүх эрх хуулиар хамгаалагдсан” гэсэн тэмдэглэл болон оюуны өмчийн анхааруулга байршсан байна.
 - 1.4. Цахим сургалтын платформд хичээл дараах мэдээллийг агуулсан байна:
 - Хичээлийн зорилго, үр дүн
 - Заах арга зүй, даалгавар, үнэлгээний бүтэц
 - 1.5. Суралцагчдад тэгш хүртээмжтэй байлгах үүднээс цахим хичээлийг агуулга дараах боломжуудаас дэмждэг байвал зохимжтой:
 - Хадмал орчуулга
 - Дохионы хэлмэрч
 - Дэлгэц уншигч
 - Хөдөлгөөнт дүрслэлд тайлбар хавсаргасан
 - Хичээлийн онцлогоос хамааран текст хувилбар, аудио хувилбар
2. Дүрс бичлэгийн бүтэц ба агуулгад тавигдах шаардлага:
 - 2.1. Цахим хичээлийн агуулгыг долоо хоногоор зохион байгуулсан байна.
 - 2.2. Нэг лекц/сэдвийн агуулга нь нийт 45-90 минутын видео бичлэг байна. Нэг лекц/сэдвийн видео нь хэд хэдэн видео бичлэгээс тогтож болох бөгөөд видео тус бүр 15 минутаас хэтрэхгүй урттай байх нь тохиромжтой.
 - 2.3. Бичлэгийн дор хаяж 30 хувь нь график, хөдөлгөөнт дүрслэл, схем зураглал агуулсан байна.
 - 2.4. Лекц, видео хичээлийн бичлэг бүрийн төгсгөлд тухайн сэдвийг бататгах зорилгоор 3 хүртэлх тест эсвэл интерактив сорил оруулсан байна.
 - 2.5. Дэлгэрүүлэн судлах линк, эх үүсвэрүүд, ном зүй хавсаргасан байна.
 - 2.6. Семинарын хичээлийн бичлэгийн дараа өөрийгөө шалгах тест, бодит жишээ, төслийн ажлын даалгавар хавсаргасан байна.
 - 2.7. Бичлэгийн танилцуулах байдал нь энгийн ойлгомжтой байна.
3. Дүрс бичлэгт тавигдах техникийн шаардлага
 - 3.1. Дэвсгэр өнгө болон үзүүлэн нь цайвар өнгөтэй, нүдэнд ачаалал бага, үзэмжтэй байна.

- 3.2. Харааны борхшээлтэй суралцагчдад ээлтэй байх үүднээс өнгөний ялгарал хангалттай байна.
- 3.3. Үзүүлэнгийн текст хар бараан өнгөтэй, үсгийн хэмжээ тохиромжтой хэмжээтэй байна.
- 3.4. Дүрс бичлэгийн нягтрал багадаа Full HD буюу 1080p (1920x1080), 16:9 харьцаатай байна.
- 3.5. Дүрс бичлэгийн секундэд бичих фреймийн тоо нь 30 fps байна.
- 3.6. Дүрс бичлэг нь агуулгаасаа хамааран секундэд бичих өгөгдлийн хэмжээ нь 6-10Mbps байна.
- 3.7. Дүрс бичлэгийн кодек нь H.264 байх ба дууны кодек нь AAC байна.
- 3.8. Дүрс бичлэг нь MP4 (.mp4) форматтай байна.
- 3.9. Орчны дуу чимээ багатай, ярианы чанар тодорхой байна.
- 3.10. Дууны төвшин дундаж, тогтвортой, хоолойг студийн орчинд чанартай бичсэн байвал зохимжтой.




МУИС-ИЙН ЗАХИАЛГААР ЦАХИМ ХИЧЭЭЛ**БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ГЭРЭЭ**

20__ оны __ сарын __ өдөр

№ _____

Улаанбаатар хот



Энэхүү гэрээг нэг талаас захиалагчийг төлөөлж МУИС-ийн сургуулийн захирал _____ овогтой _____, нөгөө талаас гүйцэтгэгчийг төлөөлж _____ тэнхимийн багш _____ овогтой _____ нар /цаашид "талууд" гэх/ Монгол Улсын Иргэний хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, МУИС-ийн цахим сургалтын журмын холбогдох зүйл, заалтыг үндэслэн харилцан тохиролцож МУИС-ийн _____ хичээлийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, үр дүнг үнэлэх талаар харилцан тохиролцож байгуулав.

1. Ерөнхий зүйл

- 1.1. Гэрээний зорилго: МУИС-ийн хичээлийг цахим хэлбэрт шилжүүлэх, гүйцэтгэгчийн боловсруулсан цахим хичээлийг сургалтад зориулан ашиглах болон бусад зохиогчийн эд хөрөнгийн онцгой эрхийг захиалагчид шилжүүлэх, захиалагч нь цахим хичээл боловсруулсан багшид гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбоотойгоор талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээний хугацаа: Талууд гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээний үүрэг дуусгавар болсноор гэрээний хугацаа дуусгавар болно.
- 1.3. Үүрэг дуусгавар болох хугацаа: Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 7 сарын хугацаанд цахим хичээлийг боловсруулан цахим сургалт хариуцсан нэгжид хүлээлгэн өгнө.
- 1.4. Цахим хичээлийг ашиглах хугацаа: 20__ оны __-р сарын __-ны өдрөөс эхлэн 20__ оны __-р сарын __-ний өдрийг дуустал нийт __ жил
- 1.5. Гэрээний нутаг дэвсгэр, хүрээ: Энэ гэрээний дагуу боловсруулсан цахим хичээлийг МУИС-ийн хөтөлбөрийн дагуу заагдах цахим сургалтад ашиглана. Захиалагч нь Монгол улсын нутаг дэвсгэр болон олон улсын хэмжээнд цахим сургалт явуулах эрхтэй.
- 1.6. Хичээлийн ашиглалт: _____ цахим сургалтын хэлбэр

2. Гэрээний төлбөр

- 2.1. Гэрээгээр боловсруулах хичээлийн багц цагийн хэмжээ, цахим хичээлийн хэлбэрээс хамааруулж "МУИС-ийн цахим сургалтын журам"-ын 3.2.2 болон 3.2.3 дугаар заалтыг баримтлан гүйцэтгэгчид олгох урамшууллын хэмжээг багц цагаар тодорхойлж нэг багц цагийн үнэлгээг гэрээ байгуулж буй оны харгалзах үнэлгээгээр тооцно.

- 2.2. Гэрээгээр боловсруулах багшийн урамшууллыг хичээлийн төрөл хэлбэрээр тодорхойлох бөгөөд энэ гэрээний Хавсралт №1-т заасны дагуу гүйцэтгэнэ. Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 2.3. Цахим хичээл боловсруулах гэрээний төлбөр болох нийт урамшуулал төгрөг болно.
- 2.4. Гэрээ гүйцэтгэгчид гэрээний төлбөрийн ____ хувийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 2 долоо хоногийн дотор гүйцэтгэгчийн _____ банкны _____ тоот дансанд шилжүүлэх ба гэрээний үүрэг дуусгавар болж, цахим хичээлийг бүрэн хүлээлгэн өгч, гэрээ дүгнэсэн акт үйлдсэн өдрөөс хойш 2 долоо хоногт багтаан үлдэгдэл төлбөрийг шилжүүлнэ.

3. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1. Захиалагч МУИС-ийн цахим сургалтын журамд заасан шаардлага хангасан, эрхийн доголдолгүй цахим хичээлийг хүлээн авах эрхтэй.
- 3.2. Гүйцэтгэгчийн хүлээлгэн өгсөн цахим хичээл агуулгын болон стандарт шаардлага хангахгүй, зохиогчийн эрхийг зөрчсөн бол нэг удаа нэмэлт хугацаа тохирч, эрхийн доголдлыг арилгах болон сайжруулахыг шаардах, гэрээг сунгах болон цуцлах эрхтэй.
- 3.3. Энэ гэрээний 1.4-т заасан хугацаанд цахим хичээлийг дахин давтан сургалтад ашиглах, хувилах, олшруулах, нийтлэх, олон нийтэд түгээх, түрээслэх эрхтэй.
- 3.4. Цахим хичээлийг ашиглах явцад хичээлийн хөтөлбөр болон бусад ач холбогдол бүхий эх сурвалжид өөрчлөлт орсон бол гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр цахим хичээлийн агуулгад нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.
- 3.5. Цахим хичээлд тулгуурлан үүсмэл бүтээл туурвихыг зөвшөөрөх буюу хориглох эрхтэй.
- 3.6. Цахим хичээлийг заах багшийг сонгох, гүйцэтгэгчээс өөр багшаар цахим хичээлийг заалгах эрхтэй.
- 3.7. Гэрээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- 3.8. Гүйцэтгэгчийн амины эрхийг хөндөхгүй ба цахим хичээлийн эхэнд цахим хичээлийг боловсруулсан багшийн нэрийг дурдах үүрэгтэй.
- 3.9. Захиалагч нь энэ гэрээний 4.1-т заасан гүйцэтгэгчийн эдийн бус баялгийн эрхийг хүндэтгэх, хамгаалах үүрэгтэй.
- 3.10. Гэрээний гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авах эрхтэй.
- 3.11. Гэрээний үр дүнг дүгнэх, сунгах, цуцлах тухай шийдвэр гаргах эрхтэй.

4. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 4.1. Гүйцэтгэгч энэ гэрээний дагуу боловсруулсан цахим хичээлийн хувьд зохиогчийн эдийн бус баялгийн эрх болон амины эрх эдлэх эрхтэй.
- 4.2. Гэрээний хүрээнд боловсруулсан цахим хичээлийн агуулгад тулгуурлан ном, сурах бичиг, гарын авлага зохиох, хэвлүүлэх эрхтэй. Энэ зүйлд зааснаас бусад хэлбэрээр захиалагчийн бичгийн зөвшөөрөлгүйгээр цахим хичээлийг ашиглах эрхгүй бөгөөд цахим хичээлтэй холбогдох зохиогчийн эд хөрөнгийн онцгой эрхийг захиалагчид бүрэн шилжүүлэн өгсөн болно.
- 4.3. Гэрээний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтан зөвшөөрч гэрээний гүйцэтгэлийг дүгнэсэн акт үйлдсэн үеэс гэрээний төлбөрөө төлөхийг шаардах эрхтэй.

- 4.4. Захиалагчаас санал болгосон цахим хичээл боловсруулах сургалтад хамрагдах үүрэгтэй.
- 4.5. Гүйцэтгэгч нь МУИС-ийн баталсан хөтөлбөрийн дагуу цахим хичээлийг боловсруулах үүрэгтэй.
- 4.6. МУИС-ийн цахим сургалтын журамд заасан шаардлага хангасан, эрхийн доголдолгүй, техникийн стандартад нийцсэн цахим хичээлийг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 4.7. Гэрээний дагуу боловсруулсан цахим хичээлийн агуулгаар МУИС-аас өөр байгууллагад хичээл заах, сургалтын болон бусад материал бэлтгэж өгөхийг хориглоно.
- 4.8. Цахим хичээл боловсруулахдаа МУИС-ийн цахим сургалт хариуцсан нэгжийн бичлэгийн студийг ашиглах эрхтэй.
- 4.9. Цахим хичээл боловсруулах явцад цахим сургалт хариуцсан нэгжээс технологийн зөвлөгөө авах эрхтэй.
- 4.10. Цахим хичээлийг бэлтгэсний дараа цахим сургалт хариуцсан нэгжээс технологийн шаардлагын, харьяа тэнхимээс агуулгын шаардлага хангасан эсэх талаар дүгнэлт гаргуулах үүрэгтэй.
- 4.11. Цахим хичээлийг цахим сургалтын платформд байршуулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 4.12. Цахим хичээлийн боловсруулалтын явцад гаргасан технологийн алдааг засаж сайжруулах үүрэгтэй.

5. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1. Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан тохиолдолд бодит хохирлыг буруутай тал нөхөн төлнө.
- 5.2. Гүйцэтгэгч харилцан тохиролцсон хуваарийг зөрчсөн, гэрээнд заасан хугацаанд цахим хичээлийг хүлээлгэн өгөөгүй бол захиалагч гэрээг цуцлах ба гэрээ цуцалсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.
- 5.3. Захиалагч нь гүйцэтгэгчийн боловсруулсан цахим хичээл бусдын зохиогчийн эрхийг зөрчсөн талаарх маргаан, санал гомдол, аливаа хариуцлага, торгууль шийтгэл, шийдвэрийг хэн нэгний өмнө хариуцахгүй бөгөөд боловсруулсан багш бүрэн хариуцна.
- 5.4. Энэ гэрээний дагуу боловсруулсан цахим хичээлийг гуравдагч этгээд хууль ёсны зөвшөөрөлгүйгээр ашиглаж буй зөрчлийг түрүүлж мэдсэн тал нь нөгөө талдаа мэдээлэх үүрэгтэй бөгөөд эрхийн зөрчлийг арилгуулахаар талуудын аль нэг нь шаардах эрхтэй.
- 5.5. Талууд гэрээний нууцлалыг чанд сахиж, гэрээний нөхцөл журмыг гадагш задруулахгүй байх үүрэгтэй.


6. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах

- 6.1 Энэ гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 6.2 Энэ гэрээг дараах тохиолдолд цуцалж болно:
- 6.2.1 Гүйцэтгэгч гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд захиалагч тал үүргээ биелүүлэх тодорхой хугацаа зааж шаардлага

тавих бөгөөд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч болно.

6.2.2 Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаанаар ажил үүргээ бүрэн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд бодитойгоор гүйцэтгэсэн ажил үйлчилгээнээс хамаарч төлбөрийг тооцон гэрээг цуцалж болно.

6.3 Талууд энэхүү гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах, сунгах талаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.



7. Бусад

7.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

7.2. Энэхүү гэрээгээр боловсруулсан цахим хичээлийн оюуны өмчийн бүх эрхийг МУИС эзэмшинэ.

7.3. Энэхүү гэрээний нөхцөл, заалттай холбоотой маргаан гарвал талууд аль болох хэлэлцээ хийх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.4. Талууд энэхүү гэрээнд заасан нөхцөлийг урьдчилан гүйцэд уншиж танилцсан, гэрээний бүх нөхцөлийн талаар харилцан саналаа илэрхийлж тохиролцсон бөгөөд талууд бүрэн дүүрэн ойлголтыг авсан болно.

7.5. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж бүрэлдэхүүн гэрээлэгч талууд тус бүр нэг хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

Захиалагчийг

төлөөлж

.....
(нэр)
(албан тушаал)
(бүрэлдэхүүн сургууль)

Гүйцэтгэгчийг

төлөөлж

.....
(нэр)
(албан тушаал)
(бүрэлдэхүүн сургууль)

Цахим хичээл боловсруулах багшийн урамшуулал

Хичээлийн нэр:

Багшийн нэр:

Тэнхим, сургууль:



Хүснэгт 1. Багшид бодогдох багц цагийн хэмжээ

Хичээлийн багц материал	Тайлбар	1 долоо хоног (цагаар)				16 долоо хоног	Багц цаг
		Бэлтгэх	Бичүүлэх	Засварлах	Нийт		
Лекц	2 багц цаг лекц	4	3	2	9	144	3
Семинар	1 багц цагийн үед	2	3	1	6	96	2
Шалгалтын сан	Бүрэн цахим хичээлийн хувьд	3	0	0	3	48	1
Нийт						288	6

Хүснэгт 2. Багшийн урамшууллын дүн

Хичээлийн нэр	Багц цагийн үнэлгээ, (төгрөг)	Багц баг	Нийт үнийн дүн (төгрөг)
/хичээлийн нэр/			
Нийт			

ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН АКТ

20... оны ... -р сарын ...-ны өдөр

Гэрээний нэр	МУИС-ийн захиалгаар цахим хичээл боловсруулах гэрээ
Гэрээний дугаар	
Гэрээнд холбогдох тушаалын дугаар	
Захиалагч	МУИС-ийн сургууль
Гүйцэтгэгч	 тэнхимийн багш
Гэрээгээр боловсруулах хичээлийн нэр	
Хичээлийн төрөл, хэлбэр	
Гэрээний эхлэх хугацаа	
Гэрээний дуусах хугацаа	
Гэрээний нийт төлбөр	
Үүнээс: Урьдчилгааны дүн	

Гэрээний биелэлтийн талаарх дүгнэлт /холбогдох нэгж бүрээр/

Дүгнэлт	Гарын үсэг	Нэр
Технологийн шаардлага хангасан эсэх тухай дүгнэлт		Хариуцсан мэргэжилтэн
Агуулгын шаардлага хангасан эсэх тухай дүгнэлт		Тэнхимийн эрхлэгч, ажлын хэсгийн ахлагч
Гэрээнд тусгагдсан бусад шаардлагыг хангасан эсэх талаарх бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн дүгнэлт		БС-ийн захирал
Цахим сургалтын платформд оруулан бэлтгэсэн хичээлийн материалыг хүлээн авсан		Цахим сургалт хариуцсан нэгж

Гэрээ гүйцэтгэлийн шийдвэр:

Гэрээний үүргээ биелүүлсэн тул гэрээний үлдэгдэл төлбөр болох
төгрөгийг олгох.

Гэрээний үүргээ биелүүлээгүй тул



Гэрээ дүгнэсэн:

Захиалагчийг

төлөөлж

.....

(нэр)
(албан тушаал)
(бүрэлдэхүүн сургууль)

Гүйцэтгэгчийг

төлөөлж

.....

(нэр)
(албан тушаал)
(бүрэлдэхүүн сургууль)